

**МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГОД ХӨГЖЛИЙН
БОДЛОГЫН ТАЛААР ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТ**

2013.03.15.

29	5.1.6.1	Экспортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг зохистой өсгөнө	1	Эрдсийн болон мал аж ахуйн гаралтай түүхий эдийн экспортыг үе шаттай бууруулж, эцсийн бэлэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх	Нийгэм эдийн засгийн үндсэн салбар болох МАА-н үйлдвэрлэлд 8.1 мянган малчин өрхөд хөдөлмөрийн насны 17.0 мянган хүн ажиллаж, жилд дунджаар 11.0-12.0 мянган тн мах, 794.7 мян тн ноос, 247.2 мян тн ноолуур, 500-600 мян ширхэг арьс, шир зах зээлд нийлүүлж байна. Сумдын мал эмнэлэг, үржлийн тасгийн мал аж ахуйн үйлдвэрлэл үржил, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн нарт ХАА-н түүхий эдийн биржийн тухай хууль түүнийг хэрэгжүүлэх арга замууд, түүхий эд бэлтгэлийн төвүүдийг байгуулах талаар 2 өдрийн сургалт зохион байгуулж, “Сургагч багш”-ийн гэрчилгээ олгон, мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн ТЭЗҮ хийгдэж, ХХААХҮЯ-нд тендер зарлагдаад байна.	30
			2	Оюуны шингэц бүхий бага оврын бүтээгдэхүүн, үйлчилгээний экспортыг өсгөх	Эсгий болон шүрэн урлал, арьс ширэн бэлэг дурсгалын зүйлийг үйлдвэрлэн борлуулж байна.	30
30	5.1.6.2	Импортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг эдийн засгийн хөгжлийн хэтийн чиг хандлагатай оновчтой уялдуулан сайжруулна	1	Импорт орлох зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих	“Ховд скай” компанид сүүний үйлдвэрлэл хөгжүүлэхэд зориулан 100 сая, “Баясгалант-Өндөр Хөхий” компанид печений үйлдвэрлэлд 100 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгууллаа.	70
			2	Өндөр технологийн болон оюуны шингэц бүхий бага оврын техник, тоног төхөөрөмжийн импортыг дэмжих	Газар тариалан, хадлан бэлтгэхэд зориулан жижиг овлын тракторыг аж ахуйн нэгж, иргэдэд 50 хувийн хөнгөлөлттэй үнээр олгож дэмжлэг үзүүлээ.	50
31	5.1.7.1	Хувийн хэвшил, Засгийн газрын байгууллагуудын түншлэлийг дэмжин хөгжүүлж, бэхжүүлнэ	1	Засгийн газар, хувийн хэвшил хоорондын зөвлөлдөх хорооны үйл ажиллагааг идэвхжүүлж, тогтмолжуулах механизмыг төлөвшүүлэх	Төр, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагын гурван талт хамтын ажиллагааны түншлэлийн гэрээ байгуулан, харилцан мэдээлэл солилцож, бизнес эрхлэгчдийг мэдээллээр ханган, зөвлөгөөн зохион байгууллаа	90
			2	Хувийн хэвшлийн үйл ажиллагаа ил тод, шударга явагдах нөхцөлийг бүрдүүлэх	Хувийн хэвшлийн үйл ажиллагаа ил тод, шударга явагдах нөхцөлийг бүрдүүлэн, тэдэнд хөнгөлттэй зээл олгоход иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлийг оролцуулан шийдвэрлэж байна.	70
			3	Хувийн хэвшлийн нийгмийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарах	Хувийн хэвшлийн нийгмийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд анхааран ажиллаж, Сум хөгжүүлэх болон ЖДҮ хөгжүүлэх сангуудаас отгосон зээлд ХХААХҮЯ, аймгийн аудитын газартай хамтран 2 удаа шалгалт хийж мониторинг үнэлгээ тогтоолоо.	90
32	5.2.1.2	Уул уурхайн салбарт байгаль орчныг хамгаалж, экологийн тэнцвэрт байдлыг хадгална	1	Уул, уурхайн ашиглалтад өртсөн талбайн нөхөн сэргээлтийг сайжруулах	Бичил уурхайг эрхлэгчдийн үйл ажиллагааны улмаас 300 гаруй га талбайн эвдэрснийг тогтоож, Дөргөн суманд хууль бусаар алт олборлогчдын хууль бус үйл ажиллагааг таслан зогсоож, 8 га талбай эвдэрснийг тогтоож, нөхөн сэргээх ажлыг хийв.	30
			2	Уурхайн олборлолтын технологид нэгдсэн стандарт мөрдүүлэх	Уурхайн олборлолтын технологид нэгдсэн стандарт мөрдүүлэн ажиллаж байна.	50
			3	Эдэлбэр газрын экологи, эдийн засгийн үнэлгээ хийж, экологийн хохирлын болон нөхөн төлбөр, хураамжийг тооцох, хариуцуулах, төлүүлэх механизмыг боловсронгуй болгох	Байгаль хамгаалагчид зэрлэг ан амьтны мониторинг хийж Биосан программд оруулж хэвшээд байна. Хууль бус загас агналтанд хяналт шалгалт хийж зөрчлийг таслан зогсоох, Ан агнуурын тухай хууль, УТХГН-ийн тухай хууль, Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээний талаар ухуулга сурталчилгаа явуулан, хяналт шалгалт хийж, 35 тор хураан авч устгалаа.	50
			6	Уур амьсгалын өөрчлөлт, уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас шалтгаалан гадаргын болон газрын доорхи усны экосистем доройтох, бэлчээр хомсдох зэрэг сөрөг нөлөөллийг	Дөргөн сумын Аргалант багийн Хөх эргийн орчимд гар аргаар алт олборлогчид гарсантай холбогдуулан аймгийн МХГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулж, Цагдаагийн газар, БОАЖГ, Хар Ус нуурын БЦГ-ын хамгаалалтын захиргаатай хамтран уг хууль бус үйл ажиллагааг зогсоох арга хэмжээг 3 удаа	30

				багасгахад анхаарч экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор гол мөрний эх, ай сав, ойн бүс, говийн баян бүрд, нуур цөөрөм, түүхийн дурсгалт газарт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохгүй байх, цаашид хэсэгчлэн хязгаарлах зорилгоор үе шаттай арга хэмжээ авч, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох	зохион байгууллаа.	
33	5.2.1.2.1	Гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ	1	Экспортын баримжаатай, оюуны шингэц бүхий өрсөлдөх чадвартай, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх	“Баруун монгол интернейшнл” компани консерев үйлдвэрлэн ОХУ-д экспортлож байна.	50
			2	Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн дэлхийн зах зээлд өрсөлдөх	“Үр жимс” хоршоо чацарганы тос үйлдвэрлэн борлуулж байна	50
			4	Оёмол, нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүн, ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх	Аймгийн төвд ахуйн үйлчилгээний цогцолбор баоьж эхлэн, Мянгад суманд “Давшил өгөөж” хоршоо ноолуур, тэмээний ноосон сүлжмэл хувцас үйлдвэрлэн борлуулж байна. ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас иргэн Н.Нямдоржид ноос боловсруулах үйлдвэр байгуулахад 100.0 сая, иргэн Б.Амарсайханд нжмэл, сүлжмэлийн үйлдвэр байгуулахад 14.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгов.	50
			6	Өөрийн оронд үйлдвэрлэх боломжтой хүнсний болон өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэлийг хөгжүүлж, импортоос хэт хараат байдлыг багасгах	Өөрийн оронд үйлдвэрлэх боломжтой хүнсний болон өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэлийг хөгжүүлж, импортоос хэт хараат байдлыг багасгах талаар анхаарч хүнсний үйлдвэрийг хөгжүүлэхэд 29 аж ахуйн нэгж, иргэнд 183.7 сая, ахуйн үйлчилгээний чиглэлээр 96 аж ахуйн нэгж, иргэнд 423.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгов.	70
			7	Өндөр технологи хэрэглэн өөрийн оронд түгээмэл тархсан барилгын материалын түүхий эдийг боловсруулж, хавтгай шил, эрдэс будаг зэрэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх	Аймагт барилгын материалын үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлж, энэ чиглэлийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг гааль болон нэмүү өртгийн татвараас чөлөөлүүлэх, хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээ авч, 6 аж ахуйн нэгж, иргэдэд 69.9 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олголоо.	30
34	5.2.1.3.2	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлдэг төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай болгоно	1	Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, тэдэнд техник, технологийн сонголт хийхэд нь туслах, төсөл боловсруулах, шалгаруулах явцад нь зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий төвүүдийг аймаг, нийслэл, сум, дүүргүүдэд зохион байгуулж ажиллуулах	Аймгийн төвд ХАҮТ-ын дэргэд 15 сая төгрөгийн санхүүжилтээр “Бизнес инкубатор төв”, Чандмань суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 20 сая төгрөгөөр “Бизнес инкубатор төв” байгуулан, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, тэдэнд техник, технологийн сонголт хийхэд нь туслах, төсөл боловсруулах, шалгаруулах явцад нь зөвлөгөө өгч ажиллаа.	70
			2	Жижиг, дунд үйлдвэрлэлийн бодлогын асуудалтай холбоо бүхий аливаа шийдвэрийг гаргахдаа тэдний ашиг сонирхлыг илэрхийлэгч мэргэжлийн холбоодын саналыг авч тусгаж байх	Жижиг, дунд үйлдвэрлэлийн бодлогын асуудалтай холбоо бүхий аливаа шийдвэрийг гаргахдаа тэдний ашиг сонирхлыг илэрхийлэгч мэргэжлийн холбоодын болон иргэний нийгмийн байгууллагын саналыг авч тусган хэрэгжүүлэв.	70
			3	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж, бизнес инкубатор байгуулж ажиллуулах	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцүүлэн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж, бизнес инкубатор байгуулж ажилан Жаргалант, Чандмань сумдад бизнес инкубатор төв байгуулан бусад сумдад үе шаттай байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	30
			4	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу олгогдож байгаа тусгай зөвшөөрлийг цахим үйлчилгээнд бүрэн шилжүүлэх	Согтууруулах ундаа худалдаалдаг түүгээр үйлчилгээ явуулдаг аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрлийн хүүль тогтоомжийн дагуу олгож байна.	90
35	5.2.1.4.1	Бүс нутгийн онцлогийг харгалзан бэлчээрийн	1	Малыг халдварт болон шимигчит өвчнөөс хамгаалах өндөр технологийг нэвтрүүлж эхлэх	Монгол мал үндэсний хөтөлбөрийн хүрээнд зооноз архаг халдварт бруцеллёз, ям, сүрьеэ, лейкоз, адууны халдварт цус багадах өвчнийг өргөн хүрээтэй	50

		болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, халдварт өвчний гаралт, тархалтыг эрс бууруулан малыг эрүүлжүүлж, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалт, экспортыг нэмэгдүүлнэ			тандах шинжилгээний дээж цуглуулах ажлын хэсэг гарч 17 сумын 54 багийн 1745 үхэр, 2264 адуу, 2894 хонь, 2925 ямаа, 605 тэмээ нийт 10433 малд тандан шинжилгээг хийж, аймгийн хэмжээнд халдварт, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга авч, шөвөг яр, боом, дуут хавдар, цусан халдварт, дотрын халдварт хордлого, сохор доголын вакцинуудыг хийж, малыг эктопаразиттаас хамгаалах зорилгоор 360 литр ивомекийг малчдад үнэгүй олгон, 1140 л ивомекийг хотоос татан аваад малчдад тараахад бэлтгээд байна	
			2	Монгол малын тэсвэрт чанарыг бататган, цус ойртохоос урьдчилан сэргийлж, биологийн боломжийг бүрэн ашиглаж, байгалийн эрсдэл даах чадварыг нь бэхжүүлэх	Сумдад цэвэр эрлийз мал өсгөх даалгавар өгч ажилласнаар 2012 оны жилийн эцсийн мэдээгээр цэвэр,эрлийз үхэр 1766, хонь 63155, ямаа 85776 тоологдсон байна.	50
			3	Малын чанар, үржлийн ажлыг сайжруулах	Шилмэл хээлтүүлэгч бойжуулах төсөлд 19,5 сая төгрөгийн хөнгөлттэй зээлийг олгосон байна. Торгууд хонины удмын санг хамгаалах зорилгоор МУСҮ-д Торгууд хээлтүүлэгч өгч үрийг малын удмын сангийн генийн санд хадгалуулах арга хэмжээ авч ажиллаа. Торгууд, Сутай хонь, Алтай улаан ямаа, Мянгад адуу, үхэр, тэмээ, адууны ашиг шимийн дундаж үзүүлэлтийг МААЭШХ, МХЕГ-тай хамтарч тогтоогоод байна	70
			4	Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар багтаамж, даацыг нэмэгдүүлэн мал аж ахуйн эрсдэлийг бууруулах	Бэлчээр ашиглалтын журам боловсуулан гаргаж сум болгон мөрдөж ажиллаж байна. Манай аймгийн нэлээд хэдэн сум дээр бэлчээр ашиглах журам зорчигдож байгаа тухайлбал Дуут, Буянт Булган гэх мэт.Арга хэмжээ авч ажиллах чиглэл үүргийг мал эмнэлэг үржлийн тасгийн дарга Засаг дарга нарт өгөөд ажиллаж байна.	30
			5	Бэлчээрийн газрыг ашиглах, эзэмших харилцааны эрх зүйн зохицуулалтыг төгөлдөржүүлж, уламжлалт аргад тулгуурласан бэлчээрийн менежментийг боловсронгуй болгож, бэлчээрийн даацад зэрлэг амьтны бэлчээр, тэжээлийн хэрэгцээг оруулан тооцох зарчмыг баримтлах	Бэлчээрийн газрыг эзэмшүүлэх талаар сум бүр өөрийн нутаг дэвсгэр дээрээ зохион байгуулж, бэлчээр ашиглалтыг сайжруулах, бэлчээрийн талхлагддаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллаж байна. Бэлчээрийн даацад зэрлэг амьтны бэлчээр, тэжээлийн оруулан мөн тусгай хамгаалалттай бүс нутагт мал оруулах зэрлэг амьтдын хэрэгцээнд зориулан байлгах арга хэмжээ авч байна.	30
			6	Биотехнологийн ололтыг нэвтрүүлж, мал үржүүлгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлэх	Зохиомол хээлтүүлгийн мэргэжлийн баг 2012 онд ирж Буянт, Эрдэнэбүрэн, Жаргалант сумын үхэрт хийж дадлагажуулагч 2 хүнийг сургаж аймгийн ХХААЖДҮГ-ын зохиомол хээлтүүлгийн лобарторт ажлуулахаар бэлтгэж байна. Малчдаас малаа зохиомол хээлтүүлгээр хээлтүүлэх сонирхолтой малчдын тоо жил эрх бүр нэмэгдэж аймгийн хэмжээнд явуулын лобартори ажиллуулах бодлого бариж байна.	10
			7	Малчдыг хөгжүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх болон мал аж ахуй эрхлэх арга ухааны чиглэлээр малчдын дунд албан бус сургалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх	Шилмэл хээлтүүлэгч бойжуулах төсөлд 19,5 сая төгрөгийн хөнгөлттэй зээлийг олгосон байна. Торгууд хонины удмын санг хамгаалах зорилгоор МУСҮ-д Торгууд хээлтүүлэгч өгч үрийг малын удмын сангийн генийн санд хадгалуулах арга хэмжээ авч ажиллаа. Торгууд, Сутай хонь, Алтай улаан ямаа, Мянгад адуу, үхэр, тэмээ, адууны ашиг шимийн дундаж үзүүлэлтийг МААЭШХ, МХЕГ-тай хамтарч тогтоогоод байна.	30
36	5.2.1.4.2	Газар ашиглалтыг сайжруулж, усалгаатай тариаланг хөгжүүлэн, биотехнологи нэвтрүүлэн газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ	2	Эрчимжсэн газар тариалан эрхэлж буй хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагыг төсөв, татварын бодлогоор дэмжих	2012 оны байдлаар нийт 11 ААН фермерийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн хэмжээнд нийт 146 цэвэр үүлдрийн үхэр байгаагаас хар тарлан-78, буган халиун-37, семанталь-31 байна. Сумдад бүртгэлийн ажлууд ихлээд байна.Фермерийн аж ахуй байгуулах чиглэлээр 131,8 сая төгрөгийн жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх зээл олгоод байна. Татварын бодлогоор дэмжиж ажиллаж байна.	30
			3	Услалтын оновчтой системийг бий болгон усалгаатай газар тариалангийн техник, тоног төхөөрөмжийг лизингээр олгох, усжуулалтын барилга байгууламжийн эзэмшилт, ашиглалтыг зах зээлийн	Цөлжилтийг сааруулах төслийн дэмжлэгтэйгээр Буянт голын сав газарт тариалан эрхэлдэг Буянт, Мянгад, Ховд, Эрдэнэбүрэн сумдад ус ашиглагчдын бүлэг ногоочидтой ажлаа уялдуулж хамтран ажиллаж, “Буянт голын сав газрын усны нөөцийн тогтвортой ашиглалт, шударга хуваарилалт” сэдэвт семинар	50

				зарчимд нийцүүлж сайжруулах	зохион байгуулан Буянт голын усыг алдагдалгүй, хэмнэлттэй, хүртээмжтэй, үр дүнтэй ашиглах ажлын төлөвлөгөөг хамтран гаргалаа. 2012 "Цөлжилтийн эсрэг хамтдаа 2" хэлэлцүүлэг зохион байгуулж, ажлын төлөвлөгөө гарган Засаг даргаар батлуулан ажиллаж байна.	
			4	Богино хугацаанд түргэн боловсордог чанартай үрийг өргөн хэрэглэж, таримал ургамлын нэр төрлийг олшруулах	2011 оны байдлаар ЦСТ, УАХ, Төмс хөтөлбөртэй хамтран үр шинэчлэх ажлыг хийсэн. Ялангуяа төмсний үр бүрэн шинчлэгдсэн үрээр тариалалт хийхээр бэлэн болоод байна.	70
			5	Өрхийн аж ахуйн үйл ажиллагааг хөнгөвчлөх орчин үеийн бага оврын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг импортолдог болон дотооддоо үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжийг дэмжих	Газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа техникийг эргэлтэд оруулах, шинэчлэх замаар газар тариалангийн үйлдвэрлэлийн техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор 2012 онд 200,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай 29 ширхэг хадлангийн болон газар тариалангийн зориулалт бүхий бага оврын тракторыг сумдад хувиарлаад байна.	50
			6	Жимс, жимсний мод үржүүлгийн газруудыг байгуулж, жимс, жимсгэний тариалалтыг өргөтгөх	Чацаргана хөтөлбөрийн хүрээнд ХХААХҮЯ, Монголын чацаргана тариалагч, үйлдвэрлэгчдийн холбооноос хамтран зохион байгуулсан чацаргана тариалах, боловсруулах технологийн сургалтыг аймгийн төвд зохион байгуулж, сургалтанд 17 сумын 200 гаруй иргэн, аж ахуй нэгжийг оролцон, харилцан туршлага судлуулж, Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран үр, үрслэг, мод, бут, жимс, жимсгэний суулгацын үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. 2012 оны эхний хагаст ХХААХҮЯ-ны төсөлд ААН шалгарч 15000 ширхэг суулгац авч тариалалт хийж, байгалийн чацарганы талбайг хамгаалалтанд авах, эзэнжүүлэх, нөхөн сэргээлт хийх зорилгоор Булган сум 5 га, Үенч сум 1 га, Эрдэнэбүрэн сум 40 га байгалийн чацаргана, жимс жимсгэний талбайг хамгаалалтанд авч сэргээлээ.	70
			7	Таримал ургамлын өвчин, хортонтой тэмцэх, сорт, сорилтын чанарыг сайжруулж, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх	Жил бүр бэлчээрийн хортон шавьжтай тэмцэх арга хэмжээг тогтмол авхаас гадна таримал ургамлын хортонтой тухай бүр тэмцэж байна.	50
			8	Ганд тэсвэртэй үр, нутагшсан сортын үрийн талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх	Үрийг нутагшуулах чанрыг сайжруулах чиглэлээр цөлжилтийг сайжруулах төсөлтэй хамтран ногоочидын бүлэг нөхөрлөл туршилт явуулж үр дүн хүрсэин ажлаа дараа жил нь ногоочдод сурталчлах ажлуудыг зохион байгуулж байна.	50
37	5.2.1.4.3	Хүнсний үйлдвэрлэлд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулна	1	Экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний болон импортыг орлох хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	Давхардсан	50
			2	Орчин үеийн техник, технологитой хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэн хүн амыг тэжээллэг, чанартай, аюулгүй хүнсээр жигд, хүртээмжтэй хангаж, гадаад зах зээлд нийлүүлж эхлэх	давхардсан	30
			3	Тохиромжтой бүс нутгуудад бөөний худалдааны төв, бирж байгуулж, хүнсний бүтээгдэхүүний борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох	Хөдөөг хоршоолох аяны хүрээнд аймгийн хэмжээнд 17 суманд МХНХ-ны тэргүүлэгч багш Д.Оюунхүүгээр ахлуулсан ажлын хэсэг 21 хоногийн хугацаанд хөдөө орон нутагт батлагдсан удирдамжийн дагуу ажиллаж, хөдөө аж ахуйн биржтэй хамтран ажиллах брокерын пүүсийг хэрхэн байгуулах түүхий эд бэлтгэлийн төвүүдийг орон нутагт байгуулах талаар хоршоологчдод ойлгуулан таниулан, биржийн тухай сургалтанд 17 сумын 720 гаруй хүнийг хамрууллаа.	50
38	5.2.1.4.4	Газар тариалангийн болон бэлчээрийн усан хангамжийг сайжруулж, хөдөөгийн хүн амын ундны усны хэрэгцээ, шаардлагад тохирсон усны нөөцийг нэмэгдүүлнэ	1	Ашиглагдахгүй байгаа бэлчээрийг худаг гаргаж, хурын ус хуримтлуулж, булаг шандны усыг нэмэгдүүлж, усжуулах	Уст цэгийн судалгааг 80 цэгт хийхээр улсын төсвийн 250 сая төгрөгөөр хийхээр төлөвлөгдөн, ажлаа дуусгалаа. Уст цэгийг тогтоосноор бэлчээрт гар худаг, өрөмдлөгийн худаг гаргах ажлын цэгүүдийг тодорхойлж гандсан талхлагдсан бэлчээрийг усжуулах арга хэмжээг жил бүр авч байна.	50
			2	Малчдын ундны усны хүрэлцээг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах	Ховд аймагт 2012 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх худаг, уст цэгийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог аймгийн Засаг даргын А/45 тоот захирамжаар байгуулж, 3 багц бүхий 31 худгыг 470,0 сая төгрөгөөр гаргахаар 3 компани тендэрт оролцож шалгаран гүйцэтгэл 70%	50

					хүлээлгэн өгөөд байна. 2013 онд үлдсэн 8 худгийг барьж хүлээлгэн өгхөөр гэрээ байгуулсан байна..	
			3	Зарим голын усны урсацын тохируулга хийж бороо, цасны усыг хуримтлуулан гантай, хуурай үед ус хэрэглэх зориулалттай гидротехникийн байгууламжуудыг бий болгох	Жил бүр малчид, иргэдийн санаачилгаар тогтвортой амьжиргаа-2 төслийн санхүүжилтээр гар худаг гаргах ажлыг зохион байгуулж, энэ улиралд 5 сумын 5 газарт худаг гаргасан. Мөн булаг шандны эхийг хамгаалах төсөл сумдад амжилттай хэрэгжиж байна.	30
39	5.2.1.4.5	Малын тэжээлийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлж, тэжээлийн шимт чанар, тэжээллэг байдлыг сайжруулах, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ	1	“Тэжээл” хөтөлбөр хэрэгжүүлж, малын тэжээл, усны хангамжийг сайжруулах	Хадлан, газар тариалан түлхүү эрхэлдэг бүс нутгуудад УАХ-д нэгдсэн 32 бүлэг нөхөрлөл хамрагдаж үйл ажиллагаа явуулж байна.Эдгээр бүлэн нөхөрлөлийг ХХААЖДҮГ, ХБХ, ТББ, ЦСТ зэрэг олон байгууллагууд дэмжиж ажиллаж байна.	30
			2	Малын тэжээлийн үйлдвэрлэл, нийлүүлэлт, хэрэглээний эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, төрийн бодлогоор дэмжих	Малын тэжээлийн үйлдвэрлэл явуулах сонирхолтой аж ахуй нэгжүүдийг зээлийн бодлого, мөн 50 дээш га бэлчээрийн талбайг тэжээлийн ургамал тариалах сонирхолтой иргэн, аж ахуй нэгжид эзэмшүүлж тариалалт нэмэгдэж байна.	30
			3	Шимт чанар сайтай, ургац ихтэй тэжээлийн шинэ төрлийн таримал нутагшуулах, үр үйлдвэрлэлийг дэмжиж, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, фермерийн аж ахуйг тэжээлийн ургамлын үрээр хангах тогтолцоо бүрдүүлэх	Цэвэр үүлдрийн фермерийн аж ахуйнуудын бие даасан байдлыг хангах тал дээр төрөөс нэлээд дэмжиж байна. Тухайбал Энхтайван, Батхуяг нарын фермерийн эзэд 10-15 га талбайд ногоон тэжээл тарих өөрсдийнхөө хэрэгцээг хангадаг болоол байна.	30
			4	Бэлчээрийн мал аж ахуйн эрсдэл даах чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор жилийн тодорхой хугацаанд малаа тэжээдэг малчдын арга ажиллагааг дэмжин хөгжүүлэх	Жил бүр залуу малчдын чуулга уулзалтыг тогтмол зохион байгуулж алдар цуутай хөдөлмөрч, туршлагатай малчдын арга туршлагаас суралцуулах, хичээл заалгах зэрэг ажлуудыг хийдэг.	30
40	5.2.1.4.6	Хөрсийг эвдрэлээс хамгаалах, үржил шимийг хадгалах, чийгийн ууршилтыг багасгахад чиглэсэн дэвшилтэт технологийг газар тариаланд нэвтрүүлнэ	1	Химийн аргаар боловсруулах уриншийн хэмжээг нэмэгдүүлэх	Уриншийг химийн аргаар бэлдхийг дэмжихгүй байна. Харин аль болох био бордоо ашиглаж тариалалт явуулах хиймийн бордооноос татгалзаж байна.	30
			2	Ногоон бордуурт болон цомхотгосон технологиор уринш бэлтгэх арга ажиллагааг нэвтрүүлэх	Уриншийг химийн аргаар бэлдхийг дэмжихгүй байна. Харин аль болох био бордоо ашиглаж тариалалт явуулах хиймийн бордооноос татгалзаж байна.	30
			3	Дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд шаардлагатай хөдөө аж ахуйн машин, техникийг худалдан авахад аж ахуйн нэгж, фермерүүдэд төрөөс дэмжлэг үзүүлэх	УХААЯ хөнгөлттэй нөхцөлтэйгээр бага оврын трактор олгож байна. Мөн 29 багт баг оврын трактор өгсөн.	50
			4	Тариалангийн талбайг сүрлэн хучлагатай болгож хашаалан хамгаалах	Тариалангийн талбайг хашиж хамгаалах талаар цөлжилтийг сааруулах төслөөс нэлээд арга хэмжээ авсан нь тухай бүс нутгийн иргэдэд суулгацуудыг үнэгүй тарааж тариалалт амьдралт дээр нь анхаарч байна.	30
			5	Хөрсний үржил шимийг хамгаалах талаархи эрх зүйн орчин, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох	Хөрсний үржил шимийг сайжруулах, элсний нүүдлийг багасгах цөлжилтийг сааруулах чиглэлээр айл бүхэн иргэн бүр, албан байгууллага аж ахуй нэгж бүр нэг мод тарих уриатай ажиллаж байна.	30
41	5.2.1.4.7	Биотехнологийг нэвтрүүлж, малын үүлдэрлэг чанарыг сайжруулан, таримлын ургацыг нэмэгдүүлнэ	2	Усалгаатай газар тариалангийн орчин үеийн технологийг өргөн нэвтрүүлж, га-гаас авах ургацыг нэмэгдүүлэх	320,0сая төгрөгийн өртгөөр баригдаж буй 100га-гийн бороожуулагч услалтын системийг Буянт сумын Захын гуу гэдэг газар бариж байгуулаад ашиглалтанд өгхөд бэлэн болоод байна.	30
			3	Хөдөө аж ахуйг харилцан бие биенээ тэтгэсэн бүтэц бүхий хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн цогцолбор болгон хөгжүүлэх	Газар тариалан, мал аж ахуй салбар харилцан бие бие нөхөж ажиллахад хагас суурин мал аж ахуйн загварыг нэвтрүүлэх шаардлага тулгараад байна. Ингэснээр хүн амыг цэвэр экологийн хүнсний бүтээгдэхүүнээр хангах боломж бүрднэ.	30
			4	Малчдын түлш, эрчим хүчний хангамжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	Өндөр настай малчдад жил бүр түлшний хөнгөлтийг нийгмийн халамжийн хэлтсээс олгодог.	10
42	5.2.1.4.8	Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээний бүх хүрээнд эрүүл ахуй, ариун цэврийн зохистой орчин бүрдүүлж, хүн амыг	1	Хүн амын эрэлт хэрэгцээнд тулгуурлан өндөр технологи бүхий хүнсний жижиг, дунд үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэн, экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангаж, экспортыг нэмэгдүүлэх	Аймгийн хэмжээнд ЖДҮ-ийг хөгжүүлэх болон Сум хөгжүүлэх санг байгуулан сүүлийн 3 жилд 243 аж ахуйн нэгж, иргэдэд 3128.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг төрийн сан болон банкны байгууллагуудаар дамжуулан олголоо.	70

		аюулгүй, хүрэлцээтэй хүнс, тэжээлээр хангана	2	Хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, лабораторийн шинжилгээг хөгжсөн орнуудын жишигт хүргэх	Хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгон, үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд анхааран, МХГ, СХЗХ болон хууль хяналтын байгууллагуудтай хамтран аттестатчилал явуулж, дүнг ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн, гарсан зөрчил дутагдлыг арилгах хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллаа.	90
43	5.2.1.5.1	Жуулчин тээвэрлэх болон жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлж, аялал жуулчлалын гол бүс нутгийн зам харилцаа, холбоо, эрчим хүчний хангамжийг сайжруулна	2	Аялал жуулчлалын гол бүс нутгуудын зам, харилцаа холбоо, эрчим хүчний хангамжийг сайжруулах ажлыг бусад салбарын хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэх	Орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэхэд анхааран орон нутгийн 20 сая төгрөгийн санхүүжилтээр нэвтийн рашаан амралтыг сэргээн засварлаж, хувийн хэвшлийн хөрөнгөөр 6 жуулчны бааз, 3 зочид буудал ашиглалтанд оруулан үйлчилгээ үзүүлж байна.	50
44	5.2.1.5.2	Аялал жуулчлалын томоохон цогцолборуудыг барьж байгуулан, аялагч, жуулчдын сонирхлыг татсан аяллын төрлүүдийг бүс нутгаар төрөлжүүлэн хөгжүүлнэ	1	Улирлын хамаарлыг багасгаж, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулах	Улирлын хамаарлыг багасгаж, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулахад анхаарч цас мөсний баярыг жил бүр Хар-Ус нуур дээр зохион байгуулж хэвшлээ.	90
			2	Салбарын бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий бүтэц бий болгож ажиллуулах	Салбарын бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий бүтэц бий болгон БОАЖГ-ыг байгуулан хариуцсан мэргэжилтэтэй болголоо.	90
			3	Монголд ирэх жуулчдын тоог нэг саяд хүргэх	Аймагт ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор орон	10
45	5.3.2	Авто замын сүлжээг өргөжүүлнэ	4	Бүсийн болон аймгийн төвүүдийг нийслэлтэй хатуу хучилттай замаар, дараагийн шатанд өөр хооронд нь холбох	АХБ-ны тусламжтайгаар хэрэгжүүлэх "Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам" төслийн хүрээнд 103,3 км, 110,8 км, 85,3 км хатуу хучилттай авто зам барих ажил 2009 оноос эхлэн ажлын гүйцэтгэл 60-70% тай явагдаж байна. Аймгийн төвийг нийслэлтэй холбох ажлын хүрээнд Манхан-Дарви чиглэлийн 100,3 км замын ажил эхлэн Манханы гүүрээс Зэрэг чиглэлд 20 км хатуу хучилттай авто замыг ашиглалтанд оруулаад байна.	10
46	5.3.3	Авто замын салбарт дэвшилтэт техник технологи нэвтрүүлж, авто зам, замын байгууламжийн чанарыг дээшлүүлж, ашиглалт, үйлчилгээг сайжруулна	1	Монгол орны байгаль, цаг уурын нөхцөлд тохирсон авто зам барих технологи нэвтрүүлж, техник, технологийн шинэчлэл хийх	Бүсийн хэмжээний барилгын материалын сорилын лаборторийг барьж байгуулах, тоног төхөөрөмжийг суурилуулах зэрэг ажил эхлэн явагдаж байна.	10
			2	Авто замын туршилт, сорилт судалгааны ажлыг сайжруулах	Замын нягтралыг тодорхойлах судалгаа хийгдэж нэвтрэн өнгөрөх тээврийн хэрэгслийн тоог гаргаж зам төлөвлөлтөнд ашиглаж байна.	10
47	5.3.8	Авто тээврийн хэрэгслээс хүрээлэн байгаа орчин, хүн ам, замын хөдөлгөөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг эрс бууруулна	1	Улаанбаатар хот болон томоохон хотуудын тээврийн хэрэгслийг шингэрүүлсэн шатдаг хийн түлшинд шилжүүлэх	Хийн станц барьж ашиглалтанд оруулсан хэдий ч шингэрүүлсэн хийгээр ажилладаг тээврийн хэрэгслийн тоо харьцангуй бага байна.	10
			2	Тээврийн хэрэгслийн татварыг байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг нь тооцон боловсронгуй болгох	Манай аймагт 2012 оны байдлаар нийт 6842 авто тээврийн хэрэгсэл байгаагаас холбогдох журмын татвар ноогдуулан ажилла байна	10
48	5.3.2.2	Сум, суурин газрын болон малчдын цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулна	1	Төвлөрсөн системд холбогдоогүй сум, суурин газруудыг цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбохын зэрэгцээ сэргээгдэх эрчим хүч болон бусад эх үүсвэрүүдийг ашиглан байнгын цахилгаанаар хангах	Ховд аймгийн бүх сумд Төвлөрсөн цахилгаан хангамжинд холбогдсон бөгөөд 2012 онд Зэрэг гол, Улаанбураа, Цагаанбулан, Цагаанбургасан, Дэлгэр, Баянсудал багийн төвүүдийг ЦДАШ, дэд станцад холболоо. Мөн Дарви сумаас Хөшөөтийн чиглэлд 35 кВ-ын ЦДАШ, дэд станцыг барьж байгуулан, Хөшөөтөөс Цэцэг сум руу 15 кВ-ын ЦДАШ, дэд станцыг ашиглалтанд оруулж сэргээгдэх эрчим хүчээр ажиллаж байсан хүчин чадлыг нэмэгдүүлэн цахилгааны байнгын найдвартай ажиллагааг хангав.	90
			2	"Буман нарны гэрэл" хөтөлбөрийн хүрээнд бүх малчин айл өрхийг нар, салхины эрчим хүчний эх	Хөтөлбөр амжилттай хэрэгжиж дууссан бөгөөд малчин айл өрхийн 90% нар салхины эрчим хүчний эх үүсгэвэрийг ашиглаж байна.	90

				үүсвэртэй болгох		
49	5.3.2.3	Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн үр ашгийг сайжруулж, хөгжлийн нэн таатай орчинг бий болгоно	1	Бүс нутгуудын эрчим хүчний системийн үр ашгийг дээшлүүлэх	Дөргөний УЦС-ын хүчин чадлыг нэмэгдүүлэхээр ажиллаж, Хөшөөтийн уурхайг түшиглэн Цахилгаан станц барих ажлыг дэмжин ажиллаж байна.	30
50	5.3.4.2	Мэдээлэл харилцааны технологийн ололтыг нийгэм, эдийн засгийн бүх салбарт өргөн нэвтрүүлнэ	1	Зайн эмчилгээ, зайн эмнэлгийн анхдагч тусламж, үйлчилгээг үзүүлдэг болгож, нарийн мэргэжлийн эмч нар зайнаас зөвлөгөө өгөх, мэргэжлийн тусламж үзүүлэх боломжийг бүрдүүлэх	Хэрэгжих боломж бүрдсэн байгаа	10
			2	Зайн банкны үйлчилгээ, зайн төлбөр тооцоо, зайн худалдаа, арилжаа, бэлэн бус мөнгөний эргэлт, нийгмийн халамжийн зайн үйлчилгээг нэвтрүүлэх	Хэрэгжих боломж бүрдсэн байгаа	50
			3	Хөдөө, орон нутагт утасгүй холбооны системийг эрчимтэй хөгжүүлж, 2015 он гэхэд үүрэн телефоны шинэ үеийн үйлчилгээг газрын суурь сүлжээг ашиглан хүн амын 60 хүртэл хувьд хүргэж, газар нутгийн 50 хүртэл хувийг зөвхөн газрын суурь сүлжээний тусламжтайгаар хамруулах	Аймгийн төвийн албан байгууллага, аж ахуйн нэгжийг өндөр хурдны интернетэд холбож, сум бүрт 2-4 үүрэн холбооны сүлжээ оруулан сум багийн хэрэглэгчдэд интернетийн сүлжээг ашиглах боломж бүрдүүлэн, Төрийн сан болон арилжааны бүх банк онлайн сүлжээнд холбогдож сургууль, эмнэлэг, цэцэрлэгийг интернетэд холбох ажил үе шаттай хийгдэж байна.	90
51	5.3.5.2	Орчин үеийн чанарын шаардлага бүхий барилга, шинэ нэр төрлийн барилгын материалын үйлдвэрлэл, нийтийн аж ахуйн салбарыг бий болгон хөгжүүлнэ	2	Барилгын материалын үйлдвэрлэлд шинэ техник, технологийг нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, нэр төрлийг нь олшруулах	Орон нутгийн түүхий эдэд тулгуурлан тоосго, барилгын дээврийн хавтан, шохой, замаск үйлдвэрлэн, туршилт хийх лабораторийн шинжилгээнд хамруулан ажиллаж байна.	30
			4	Орон нутгийн түүхий эдийн нөөцөд түшиглэсэн барилгын материалын үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх	Цементийн үйлдвэр байгуулах ТЭЗҮ боловсруулан ажиллаж байна.	30
52	5.3.5.3	Хүн амын орон сууцны хангамжийг эрс сайжруулна. "Орон сууц" үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ	3	Гэр хорооллыг оршин суугчдынх нь оролцоотойгоор орон сууцны хороолол болгон хөгжүүлж, хүн амын худалдан авах чадварт тохирсон орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх	Ажил эхлэх шатандаа явагдаж байгаа	10
			4	Бага орлоготой иргэд, нийгмийн эмзэг хэсэгт зориулсан орон сууцны татаас, хөнгөлөлтийг бий болгох	Нийт 68 айлын орон сууц барьж ашиглалтанд оруулан хөнгөлөлттэй зээлд хамруулсан.	10
			5	Орон сууцны шинэ хотхон, хорооллын дэд бүтцийг байгуулахад хувийн хэвшлийн оролцоог дэмжих	"Шинэ хорооллын төлөвлөгөө"- г боловсруулан 245 га газрыг шинээр төлөвлөн ажиллаж байна. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 456 айлын орон сууц барих хамтран ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлээд байна.	30
			6	2021 он гэхэд айл өрхийн дийлэнх олонхийг орон сууцтай болгох	Жил бүр 36-48 айлын орон сууцны барилгыг шинээр ашиглалтанд хүлээн авч иргэдэд ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэв.	10
53	5.3.5.4	Хот суурингийн газар ашиглалтыг сайжруулж, эд хөрөнгийн бүртгэлийн тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгоно	2	Газрын мэдээллийн үндэсний системийг бий болгон энэ талаархи мэдээллээр олон нийтэд шуурхай үйлчилдэг болгох	Аймгийн хэмжээнд сумдын Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, сумын төвийн, хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийлгэх ажлыг эхлүүлээд байна.	10
			3	Газрын мониторингийн сүлжээ бий болгож, доройтолд орж эвдэрч, талхлагдсан газрыг нөхөн сэргээж сайжруулах хөтөлбөр, төслүүдийг боловсруулан хэрэгжүүлэх	Судалгаа хийгдэж байна.	10
			4	Үл хөдлөх эд хөрөнгийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүрэн хамруулж, өмчийн бүртгэлийн системийг боловсронгуй болгон бэхжүүлэх	Бүртгэлийн системийг сайжруулан тоног төхөөрөмж материаллаг баазыг бэхжүүлэв.	30
54	5.4.1	Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт, удирдлагыг	1	Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсийн 2015 он хүртэлх хөгжлийн хөтөлбөрүүдийг	Хэрэгжих шатандаа	30

		боловсронгуй болгож, бүс нутгийн хөгжлийг түргэсгэнэ		хэрэгжүүлэх		
			2	Бүсийн тулгуур төв болох Ховд, Улиастай, Эрдэнэт, Хархорин, Дархан, Зуунмод, Өндөрхаан, Чойбалсан хотуудын болон аймаг, бичил бүсийн хөгжлийн хөтөлбөрүүд, суурин газруудын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх	Хэрэгжих шатандаа.	50
			3	Бүс нутгуудын удирдлагын оновчтой тогтолцоо, бүтцийг бүрдүүлж ажиллуулах	Баруун бүсийн зөвлөгөөнийг тогтмол хийж, баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажиллаж байна.	30
55	5.4.2	Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсийн эдийн засгийн өсөлтийг хөгжлийн хүчин зүйл болгож, Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлнэ. "Хөдөөгийн хөгжил" үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.	1	Улс орны болон бүсийн хөгжлийг хурдасгах "зүтгүүр" болох үндэсний болон бүс нутгийн хэмжээний томоохон төслүүдийг оновчтой тогтоон хооронд нь уялдаатай хэрэгжүүлж, ажлын байрыг олноор бий болгож, ажилгүйдэл, ядуурлыг эрс бууруулах	Улс орны болон бүсийн хөгжлийг хурдасгах "зүтгүүр" болох үндэсний болон бүс нутгийн хэмжээний томоохон төслүүдийг оновчтой тогтоон хооронд нь уялдаатай хэрэгжүүлж, ажлын байрыг олноор бий болгож, ажилгүйдэл, ядуурлыг эрс бууруулахад Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөө чиглүүлэн боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	90
			2	Бүс нутгуудад аж үйлдвэр, үйлчилгээний салбарын хөгжлийг түргэсгэж, хөдөө аж ахуйг хөгжүүлж, эдийн засгийн салбарын бүтцийг боловсронгуй болгох	Баруун бүсийн тулгуур төв болгох зорилт тавьн ажиллаж байна. ХАА-н салбарыг цогцоор нь хөгжүүлж ХАА-н түүхий эдийн боловсруулах цэвэрлэх байгууламж бариж ашиглалтанд оруулснаар баруун бүсийн мал аж ахуйн түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх боломжтой болж байгаа юм.	30
			3	Бүсийн тулгуур төв, аймгийн төвүүд, томоохон уул уурхайн үйлдвэрүүдийг түшиглэн эрчимжсэн мал аж ахуй, усалгаатай газар тариаланд суурилсан фермерийн аж ахуйн оновчтой сүлжээ бий болгон хөгжүүлэх	Хөшөөгийн уурхайг түшиглэж мал аж ахуйн салбарыг дэвшилтэд технолги нэвтрүүлж тухайн бүс нутгийг цэвэр экологийн сүү сүүн бүтээгдэхүүнээр хангах фермерийн аж ахуйг дэмжиж, тухайн бүс нутгийн хоршооны гишүүн малчдыг зээлийн бодлогоор дэмжиж сум хөгжүүлэх сангийн зээл мөн цаашлаад жижиг дунд үйлдвэрийн зээлийн бодлогоор дэмжиж байна.	50
			5	Бүс нутгуудад үйлдвэрлэлийн болон нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэн, бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлж, шилжих хөдөлгөөнийг сааруулах	Бүс нутгуудад үйлдвэрлэлийн болон нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэн, бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлж, шилжих хөдөлгөөнийг сааруулахад анхааран Хөшөөтн Ярантын чиглэлийн хатуу хучилттай авто зам барьж, бүх сумдыг байнгын цахилгааны эх үүсвэртэй болголоо.	100
56	5.4.4	Хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг эрс багасгаж, бүс нутгуудад мэдлэгт суурилсан эдийн засгийг эрчимтэй хөгжүүлнэ	1	Үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагааг жигдрүүлж, бүс нутгуудад экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөх	Үйлдвэрлэл, технологийн паркын үйл ажиллагааг жигдрүүлж, бүс нутгуудад экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөх асуудал улсын төсөвт тусгагдаагүйгээс шалтгаалан хэрэгжээгүй.	10
			2	Үйлдвэрлэлийн дэд бүтцийн хөгжлийг хурдасгаж, бүс нутгуудын хатуу хучилттай авто замын болон эрчим хүчний сүлжээг байгуулж дуусгах	2016 онд Нийслэлтэй болон Урьд, Хойд хөрш оронтой хатуу хучилттай авто замаар холбогдох боломж нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.	30
			3	Бүс нутгуудад мэдээлэл, харилцаа холбооны орчин үеийн сүлжээг бий болгох	2012 онд 9 сумыг өндөр хурдны шилэн кабельд холбож 34 багийн төвийг үүрэн холбоо, интернетэд холбохоор ажиллаж байна	90
			4	Аялал жуулчлал, боловсруулах үйлдвэрлэлийн салбарыг бүс нутгуудын эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгох	Аялал жуулчлалыг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, жуулчны бааз 6, зочид буудал 3 шинээр байгуулагдан, Нэвтийн рашаан амралтыг сэргээлээ.	90
57	6.1	Байгаль орчны бохирдол, доройтлыг хязгаарлан зогсооно	1	Байгаль орчинд учруулсан хохирлын эдийн засгийн үнэлгээнд тулгуурлан нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлэх	Бичил уурхайг эрхлэгчдийн үйл ажиллагааны улмаас 300 гаруй га талбайн эвдэрснийг тогтоож, Дөргөн суманд хууль бусаар алт олборлогчдын хууль бус үйл ажиллагааг таслан зогсоож, 8 га талбай эвдэрснийг тогтоож, нөхөн сэргээх ажлыг хийв.	30
			2	Улаанбаатар болон томоохон хот суурин газрын орчны бохирдлыг багасгах эрх зүй, эдийн засаг, удирдлага, зохион байгуулалтын нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх	Агаарын бохирдлыг багасгах зорилгоор аймгийн Засаг даргын албан даалгавар гаргаж, нам даралтын уурын зүүхаар байрныхаа халаалтыг шийдвэрлэсэн аж ахуйн нэгжүүдэд төвлөрсөн халаалтанд холбох эсвэл цахилгаан халаагуртай болох үүрэг даалгавар өглөө.	30
			3	Улаанбаатар болон томоохон хотуудын агаарын бохирдлыг бууруулах асуудлаар хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	Аймгийн Засаг даргын албан даалгавар гаргав.	30

			4	Сэргээгдэх эрчим хүч ашиглах хувь хэмжээг нэмэгдүүлж, нар, салхи, усны эрчим хүчний эх үүсвэрийн дан болон хоршсон хэрэглээг хөгжүүлэх	Сэргээгдэх эрчим хүч ашиглах хувь хэмжээг нэмэгдүүлж, нар, салхи, усны эрчим хүчний эх үүсвэрийн дан болон хоршсон хэрэглээг хөгжүүлэх зорилгоор Дөргөний УЦС-ыг түшиглүүлэн Нар, салхины станц байгуулах төсөл боловсруулаад байна.	10
			5	Хот, суурин газрын хатуу хог, хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, ялган ангилах, дахин боловсруулах, эргүүлж ашиглах, байгальд халгүй аргаар устгахад шинэ технологи, менежментийн цогц бодлого хэрэгжүүлж, ажлын байр шинээр бий болгох	Дэлхий нийтээр цөлжилттэй тэмцэх бүтээлч ажлын хүрээнд “Буянт гол ижий” сэдэвт хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж, уг ажилд 26 байгууллага, аж ахуй нэгжийн 310 гаруй ажилтанууд оролцож 56 машинг хог хаягдлыг зайлуулав.	50
			6	Киотогийн протоколын цэвэр хөгжлийн механизмын хүрээнд хүлэмжийн хийг бууруулах хамтарсан төсөл хэрэгжүүлж, улмаар зах зээлийн үнээр худалдах		10
			7	Байгаль орчныг хамгаалах хяналтын тогтолцоог дэлхий нийтийн жишгийн дагуу бүрдүүлэх	Ховд аймагт улсын төсвийн болон гадаад орон, хандивлагчид, аж ахуйн нэгж, иргэдийн хандив тусламжаар баригдаж буй хүүхдийн паркийн 1.5 га газрыг Швейцарийн хөгжлийн агентлагийн нэрэмжит хэсгийг төслийн санхүүжилтээр тохижуулж, түүнийг хийхэд тус аймгийн эко-сургуулийн хүүхдүүдийн оролцоог хангасанаар хүүхдүүд өөрсдийн бүтээсэн ногоон булантай болж, төрөл бүрийн арга хэмжээг үнэ төлбөргүй зохион байгуулах боломжтой болов.	30
58	6.2	Газар, газрын хэвлийн баялгийг зохистой ашиглах нэгдсэн бодлого хэрэгжүүлнэ	3	Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэн түүний удирдлагын тогтолцооны оновчтой бүтцийг бий болгож, орчин үеийн шаардлага хангасан хамгаалалтын менежментийг хэрэгжүүлэх	Булган гол – Их Онгогын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааг шинээр байгуулах тухай Булган сумаас ирүүлсэн саналыг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж байгаль орчин аялал жуулчлалын яаманд уламжиллаа.	30
59	6.3	Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ. “Ус” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ	1	Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах харилцааг зохицуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгож, ус хэмнэх усны нөөцийн менежмент, бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Манхан Мөст, Эрдэнэбүрэн, Үенч сумдад тус бүр 1, Зэрэг, Манхан сумдад Ус ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах төслийн санхүүжилтээр 4 булаг шандны эхийг хамгаалан тохижуулж, Буянт голын сав газрын зөвлөл, ЦСТ-тэй хамтран Буянт голын дагуу онцгой хамгаалалтын бүсийг 200 м тогтоож, тэмдэгжүүлэн орчны бохирдлыг буурууллаа.	50
			2	Гадаргын усны тодорхой хэсгийг аж ахуйн эргэлтэд оруулан арвижуулах замаар хүн ам, үйлдвэрлэлийн усан хангамжийг шийдвэрлэх	Тогтвортой амьжиргаа-2 төслийн санхүүжилтээр Булган сумын Баянсудал багт 140 м урт, 60 см өргөн, 1,5 м өндөр усны хамгаалалт далан байгуулж 100 га талбай усжуулан нөхөн сэргээж, хөрсний элэгдэл, элсний нүүлтийг сааруулан, Үенч сумын Нарийн гол багийн Нүцгэний булгийг хамгаалж 1 га талбайг сэргээж, Цэцэг сумын Хажинга багийн Зүүн давааны булгийг хамгаалан 50 гаруй өрхийн 1000 гаруй мал усаар хангагдах боломж бий болгож, Мөст сумын Могой хар, Баянхайрхан, Тавтын булгуудыг хамгаалан тохижуулж малчдын бүлэг нөхөрлөлдэд эзэмшүүлээ.	30
			3	Хотуудыг болон уул уурхайн үйлдвэрлэлийг хэрэгцээт усаар хангах усны нөөцийг нэмэгдүүлэх	Мянгад сумын Цагаанбулан багийн нутаг Халзан бүргэдтэй ууланд хайгуул хийх NREC ХХК-ны геологийн баг, Өрмийн баг, геофизикийн баг, үйлчилгээний багт ажиллах ажилчдын ая тухтай ажиллах, амрах нөхцлийг хангаж, тохилог гэр сууц, амт чанар сайтай, эрүүл аюулгүй хоол хүнс, халуун ус, угаалгын газрын үйлчилгээтэй, тухлаг орчныг бий болгох, өрмийн машин техникийг шатахуунаар цэнэглэх, шаардлагатай тээврийн үйлчилгээ үзүүлэх зэрэг	90

					хайгуулийн ажлын үед чухал хэрэгцээтэй үйлчилгээг чанар, стандартын өндөр түвшинд хангасан, хээрийн судалгааны ангийн бааз 2012 оны 4 дүгээр сар 23-наас 2012 оны 6 дугаар сарын 30 хүртэл хугацаатай Мянгад сумын 12335А тусгай зөвшөөрөл бүхий Ар Хүрэн нэртэй талбай, 6911А тусгай зөвшөөрөл бүхий Халзан Бүрэгтэй талбайд Геологийн баг, Өрмийн баг, Геофизикийн баг, Үйлчигээний баг, Усны тээврийн багт бүгд 50 хүн, том жижиг 10 машин, техник тоног төхөөрөмжтэйгээр ажиллаж, төсөл хэрэгжүүлэгч NREC ХХК нь топогеодезын зураглал, байгалийн ховор элементийн хайгуулийн өрөмдлөг хийж байна. Зөөврийн усыг нэг удаад 6 тн-оор нөөцлөн авч уг усаа шүүлтүүрээр шүүн дахин хэрэглэх замаар эргэлтэнд оруулж усны алдагдалгүй ажиллахаар тооцож, усны ууршилт, алдагдлыг хоногт 30 хувиас хэтрэхгүй гэж үзвэл хоногт 1500 орчим литр усаар нөөцөлсөн усаа сэлбэж ажиллах хугацаандаа өрөмөнд 100 орчим тн ус, унд ахуйд 220 тн нийт 330 тн ус зарцуулав.	
60	6.4	Ойн нөөцийг тогтвортой ашиглаж, ой хамгаалах, нөхөн сэргээх, экологийн тэнцвэрийг хадгалах нөхцөлийг хангана	1	Ойн санд сансрын мэдээ ашиглаж, зайнаас тандан судлах аргаар хайгуул, судалгаа хийж, тархалт, бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоон ойн зураглал, ойн тогтвортой менежментийн хөтөлбөр боловсруулж, газар зүйн мэдээллийн тогтолцоонд суурилсан ойн мэдээллийн сан байгуулах	Аймгийн ИТХТ-ийн 2008 оны 111 дүгээр тогтоолоор сум бүрт "Байгаль хамгаалах сан" байгуулан байгалийн нөөц баялгийг ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувийг төвлөрүүлэн, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилд зориулан зарцуулж, хяналт тавих ажлыг сайжруулан ажиллаж байна.	50
			2	Стратегийн дунд хугацааны зорилтын хүрээнд уур амьсгалыг зөөлрүүлж, цөлжилт, хөрсний эвдрэл, түйрэн, элсний нүүдэлтэй тэмцэх зорилгоор ойг нөхөн сэргээх, говь, хээрийн бүсэд мод тариалж ногоон зурвас байгуулах	Ойн тухай хууль, үндэсний хөтөлбөрийн хүрээнд улсын төсвөөр ойн зурвас, байгуулах 30 га ажлыг "Ховд Сафари" ХХК, "Үр жимс хоршоо" тус бүр 5 га, "Уламдэлгэрэх төгөл" ББН, сум дын ойн анги тус бүр 10 га талбайд гүйцэтгэж, бүх нийтээр мод тарих хаврын ажилд 16 сум идэвхийлэн оролцсоноос Жаргалант сум 5282 ш, Булган 2700, Мянгад 2200, Үенч 1700, Буянт 1500 мод тарьж бусдыгаа хошуучилан ажиллаа. Бүх нийтээр мод тарих ерөнхийлөгчийн зарлигийн хүрээнд аймгийн хэмжээнд 245 аж ахуйн нэгж, 4520 иргэд мод тарьж нийт 16056 мод таригдсан байна. 2012 оны хагас жилийн байдлаар мод тарихад улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөс нийт 77.3 сая төгрөг зарцуулаа.	100
			3	Ой хамгаалах ажилд дэвшилтэт менежментийн арга хэлбэрийг нэвтрүүлж, ойн сангийн 20 хүртэлх хувийг нутгийн иргэд, нөхөрлөлд гэрээгээр эзэмшүүлэн ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх	Заган ойг хамгаалах тухай Байгаль орчны сайдын 2011 оны 269 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор Алтай өврийн заг бүхий 3 суманд загийг түлшинд хэрэглэхийг хориглосон Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоол, Үенч, Алтай Булган сумуудын Засаг дарга нар захирамж гарган заг түлэхийг хориглож, түлшний бусад эх үүсвэр болох нүүрсийг өвөл түлшинд ашиглах, зуны цагт хийн түлш, аргал зэргийг ашиглуулахаар боллоо	70
61	6.5	Амьтан, ургамлын аймгийн нөөцийн хомсдолыг хязгаарлаж, тэдгээрийг байгалийн жамаар нөхөн сэргээх, тогтвортой ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ	2	Ан амьтны нөөц, байршил нутгийг тогтоон хамгаалахад зориулагдсан дотоод, гадаадын хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхүйц олон улсын байгууллага, хандивлагч орон, хувь хүний дэмжлэгтэй урт, богино хугацааны төслийг үр ашигтай хэрэгжүүлэхийг дэмжих	Алтай Соёны төслийн санхүүжилтээр Ховд аймгийн "Биологийн олон янз байдлыг хамгаалах", "Монгол Алтайн нурууны биологийн төрөл зүйлийг хамгаалах стратеги төлөвлөгөөг" хэрэгжүүлэн ажиллаж байна. Аргаль хонь, янгир ямааны судалгааг 2008 онд Монераль ХХК, 2009 онд ШУА-ын биологийн хүрээлэн, Амьтан асралт ХХК тус тус хийж тархалт, тоо толгой, нөөцийг тогтоолоо. ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын Алтай Соёны бүсийн салбар, Ховд их сургуулийн эрдэмтэн, багш судлаач нар Хар ус нуурын БЦГ, Мянган Угалзатын БЦГ-ын амьтны судалгаа, Булган голын байгалийн нөөц газрын төв азийн минжний судалгааг, Геоэкологийн хүрээлэнгээс Хар-Ус нуурын УТХГН-ын хамгаалалтын захиргаатай хамтран Хар нуур, Хар-Ус нуурын загасны судалгаа хийлгэлээ.	50
			3	Ховор, нэн ховор ургамлын тархац нутаг, нөөцийн судалгаа хийх, удмын санг хамгаалах, генийн сан	Ховд, Говь Алтай аймгийн МХГ, БОАЖГ, Говийн их дархан цаазат газрын "Б" хэсгийн хамгаалалтын захиргаа, хилийн цэргийн 0132 дугаар анги, Гаалийн	50

				байгуулах, бүртгэл, мэдээлэл-хяналт шинжилгээний тогтолцоо бүрдүүлэх, ашиглалтыг зохицуулан төлөвлөх, сэргээн ургуулах, тарималжуулах ажил зохион байгуулах	газар хамтран “Байгалийн эсрэг гэмт хэргийн өнөөгийн төлөв, цаашдын зорилт” сэдэвт сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж зөвлөмж гарган хэрэгжүүллээ.	
62	6.6	Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтөд дасан зохицож, сөрөг үр дагаврыг бууруулах чадавхийг бүрдүүлж хэрэгжүүлнэ	1	Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн төлөв байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоож, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн бодлого хэрэгжүүлэх	Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн төлөв байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоож, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн бодлого хэрэгжүүлэн ажиллаж байна.	50
			2	Байгаль, цаг уурын нөлөөллийн улмаас хуурайшин гандаж, доройтолд өртсөн болон өртөх магадлал бүхий газар нутгийн төлөв байдлыг тодорхойлж, тухайн бүс нутгийн онцлогт дасан зохицох чадавхийг бэхжүүлэх	Аймгийн УЦУОША-ыг цаг уурын хөдөлгөөнт 724Х радорын машин, JFJ төрлийн пуужин харвах төхөөрөмж, газрын генератор зэрэг тоног төхөөрөмжөөр хангаж, хур тунадас нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж байна.	100
			3	Байгаль, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицсон, тэсвэрлэх чадвар сайтай үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамлын төрлийг сонгон тариалах, шинэ төрөл, сортыг бий болгох, газар тариалангийн дэвшилтэт арга, технологи боловсруулж нэвтрүүлэх	Монгол төмс” хөтөлбөр хэрэгжиж газар тариалан эрхэлдэг Мянгад, Буянт, Булган, Эрдэнэбүрэн, Ховд, Манхан, Жаргалант сумдад албан бус үр үржүүлэгч 16 тариаланч тариалалт хийж нийт 60 тн элит сортын төмсний үрийн нөөцтэй боллоо. Цөлжилтийг сааруулах төсөл Буянт голын сав дагуух тариалан эрхлэгч 32 бүлгүүдийн төмсний үрийг шинэчлэх зорилгоор “Монгол төмс” хөтөлбөрөөс 2009 онд 10 тн төмсний “Санте” сортын элит үрийг авч тариаланчдад нийлүүлснээр 65 тн Санте сортын төмс хураан авч байсан бол 2010 онд 100-аад тонн Санте сортын төмсний үр хураан аваад байна. 2010 онд хүнсний ногооны үрийг шинэчлэх зорилгоор ХХААХҮЯ-ны Ногоон хувьсгал хөтөлбөрөөс сонгины хар үр 5 кг, төл сонгины 15 кг, манжингийн 5 кг, луувангийн 5 кг, хүрэн манжингийн 10 кг, өргөст хэмхний 2 кг, бөөрөнхий байцааны 3 кг үрийг авч тариаланчдад нийлүүллээ. 2011 онд Ногоон хувьсгал хөтөлбөрийн хүрээнд төмсний үр 4 тн, төл сонгины үр 20 кг, манжин 10 кг, лууван 10 кг, хүрэн манжин 10 кг, өргөст хэмх 1000 ширхэг, бөөрөнхий байцаа 3 кг үрийг аж ахуйн нэгж, иргэдэд нийлүүллээ.	100
			4	Бүс нутгийн бэлчээрийн даацад тохирсон малын тоо толгой, сүргийн бүтцийг бүрдүүлэх талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх	Өндөр ашиг шимтэй сүү махны үхэр үржүүлэх чиглэлээр төсөл шалгаруулж, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих дэд сангаас иргэн аж ахуйн нэгжид зээл олгуулах арга хэмжээ авч, үржлийн бүртгэлийн программыг ашиглаж байна	50
			5	Байгаль, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицсон, үр ашигтай, биологийн чадамж сайтай бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлэх	Малын чанар сайжруулж, ашиг шимийг нэмэгдүүлэх чиглэлээр амжилт гаргасан малчин, малчдын бүлэг, фермерийг шагнаж урамшуулах болзол, журмыг аймгийн Засаг даргын 2009 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 273 дугаар захирамжаар шинэчлэн баталж шагнаж урамшуулах ажлыг жил бүр зохион байгуулж хэвшлээ.	30
			6	Уур амьсгалын өөрчлөлт болон цөлжилт, тэдгээрт дасан зохицох, даван туулах арга зам, сөрөг үр дагаврыг бууруулах талаар олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, мэдлэг олгох, мэдээлэл, сурталчилгааны ажлыг өргөжүүлэх	Цөлжилттэй тэмцэх аймгийн дэд хөтөлбөрийн 2012 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргах хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлэгт сумын Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, газрын даамал, мал эмнэлэг үржлийн тасгийн бэлчээр, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн, бэлчээрийн менежментийн холбооны ажилтан, ТА-2 төслийн зохицуулагч болон холбогдох мэргэжлийн байгуулагуудын төлөөлөл 166 хүн оролцож санал бодлоо солилцож, 2012 онд хийх ажлын төлөвлөгөө гаргалаа.	70

ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС